

## **ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХОЛБОГДОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 4 дүгээр сарын 08-ний өдөр шинэчлэн батлагдсан зохион байгуулалтын бүтцийн хүрээнд Гүйцэтгэх захирал, 1 газар, 5 хэлтэст нийт 31 орон тоотой ажиллахаар төлөвлөгдсөн бөгөөд 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 25 удирдах болон гүйцэтгэх ажилтантайгаар “Оюу Толгой” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Санхүү, шинжилгээний хэлтсийн Мэдээллийн шинжээч мэргэжилтэн, Санхүүгийн загварчлал хариуцсан мэргэжилтний сул ажлын байранд хүний нөөцийн нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулж, шалгарсан хоёр ажилтантай туршилтаар ажиллуулах болон хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан.

Хүний нөөцийн чадавх, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор нийт ажилтнуудад зориулж Архивын Ерөнхий Газар, Тагнуулын Ерөнхий Газраас мэргэжилтнүүдийг урьж “Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, анхаарах асуудал” сургалтуудаас гадна Мэргэжлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр Рио Тинто компани болон Австрали улсын Күйнслэнд мужийн их сургуулийн хамтран зохион байгуулж буй “Өмнийн говийн далд уурхайн институт”-ын мэргэжил дээшлүүлэх Хариуцлагатай орон нутгийн харилцаа сургалт, Европын Холбооны Тогтвортой Санхүүгийн Зөвлөх Төв (SFAH)-ийн хүрээнд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Тогтвортой байдлын төлөөх санхүүгийн төвөөс (UNDP FC4S) хэрэгжүүлж, Сангийн яамнаас зохион байгуулсан “Тогтвортой байдлын удирдлага”, МУУҮА-ын “Хариуцлагатай уул уурхай” зэрэг сургалтуудад холбогдох ажилтнууд хамрагдлаа.

Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн гамшгаас хамгаалах улсын албаны бэлэн байдлын үзлэгт 2025.05.22-23-ны өдрүүдэд хамрагдаж компанийн мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, бэлэн байдлын талаар танилцуулж ажиллав.

### **Байгууллагын соёлыг сайжруулах хүрээнд**

Ажилтнуудын ахуй, нөхцөл, хэрэгцээ шаардлагыг дэмжих зорилгоор цалингийн болон шаардлагатай бусад төрлийн зээл, банкны үйлчилгээг харьцангуй бага хүү, шимтгэл, хураамжтай байх таатай нөхцөлөөр авах боломжийг бүрдүүлж, харилцагч Голомт банктэй энэ төрлийн гэрээний нөхцөлийг сайжруулан, шинэчлэн байгуулж хамтран ажиллаж байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах, оновчтой болгох зорилгоор дотоод дүрэм журам, хэм хэмжээг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан холбогдох баримт бичгүүдийг шат дараатайгаар шинэчилж байна. Хөдөлмөрийн дотоод журам, Гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэн баталсан ба ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох бусад журмуудын төслийг боловсруулаад байна.

Нийт ажилтнуудын санал хураалтын үндсэн дээр “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, байгууллагын “Ёс зүйн дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

---oOo---

Мэдээлэл авах: “Эрдэнэс Оюу Толгой”  
ХХК, Бүтээмж, засаглалын хэлтэс,  
Ц.Ганзориг, [ganzorig.ts@eot.mn](mailto:ganzorig.ts@eot.mn), 7007-8085